# БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 26 өдөр　　　　　Дугаар А/245　　　　　Булган сум

Аймгийн малчдын зөвлөгөөн
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны VII/47 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын Ууган Хөдөлмөрийн баатар, алдарт хоньчин Зундуйн Очирын мэндэлсний 120 жилийн ойг тохиолдуулан “Аймгийн малчдын зөвлөгөөн”-ийг 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Булган сумын Хөгжимт жүжгийн театрт зохион байгуулсугай.

2.Малчдын зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, 29,925,000 (хорин есөн сая есөн зуун хорин таван мянга) төгрөгийг Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

3.Дээрх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, арга зүй удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА　　　　　Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010811

Аймгийн Засаг даргын 2025 оны 06
дугаар сарын 26-ны/ний өдрийн А/445
дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

## АЙМГИЙН МАЛЧДЫН ЗӨВЛӨГӨӨНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч) |
| Гишүүд: | Г.Гантулга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| | М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга) |
| | Э.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Ч.Шүрэнцэцэг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| | Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга) |
| | Б.Буянбадрах (Хишиг-Өндөр сумын Засаг дарга) |
| Нарийн бичгийн дарга: | М.Жавзандолгор (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн хэлтсийн дарга) |

Аймгийн Засаг даргын 2025 оны 06
дугаар сарын 26-ны/ний өдрийн А/445
дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

## ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Зардлын нэр | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт |
|---|---|---|---|---|
| 1 | Хоолны зардал | 250 | 30,000 | 7,500,000 |
| 2 | Цайны завсарлага | 250 | 20,000 | 5,000,000 |
| 3 | Анонс | 30 мкв | - | 300,000 |
| 4 | Гарын авлага | 250 | 6,500 | 1,625,000 |
| 5 | Хүлээн авалт | 250 | 50,000 | 12,500,000 |
| 6 | Мандат, урилга | 250 | 12,000 | 3,000,000 |
| | **Бүгд** | | | **29,925,000** |